



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/101/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Азуре Хүлүг Аудит ХХК Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Төлбөрийн акт.....	8
3.2 Албан шаардлага	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Т.УРАНЧИМЭГ ТАНАА**

2026.02.16 № 37

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын ерөнхий боловсролын сургууль 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын ерөнхий боловсролын сургууль 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 146,161.2 мянган төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

4826050124

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 90.2 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	180,029,685.47	276,620,518.21
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	180,029,685.47	276,620,518.21
31210	Төгрөг	180,029,685.47	276,620,518.21
31211	Төрийн сангийн харилцах	173,123,673.47	276,620,518.21
31218	Ахмадын сангийн харилцах	6,906,012.00	-
33	АВЛАГА	2,058,599.76	14,105,049.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,176,682.76	-
33102	НДШ-ийн авлага	808,535.06	-
33103	ХАОАТ-ын авлага	368,147.70	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	13,392,932.00
33500	Бусад авлага	881,917.00	712,117.00
33510	Байгууллагаас авах авлага	61,800.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	820,117.00	712,117.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59,034,523.04	60,447,452.17
35100	Түүхий эд материал	35,613,925.77	38,952,325.77
35110	Тусгай зориулалттай материал	35,613,925.77	38,952,325.77
35400	Хангамжийн материал	23,420,597.27	21,495,126.40
35410	Бичиг хэргийн материал	1,752,600.00	1,121,000.00
35420	Аж ахуйн материал	18,870,447.27	15,388,630.00
35450	Барилгын засварын материал	100,000.00	-
35460	Хүнсний материал	2,697,550.00	4,029,250.00
35470	Бусад хангамжийн материал	-	956,246.40
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	241,122,808.27	351,173,019.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,488,306,376.74	1,406,646,961.01
39200	Биет хөрөнгө	1,448,881,100.77	1,368,045,173.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,232,597,168.73	1,232,597,168.73
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(107,509,979.46)	(130,160,865.82)
39203	Авто-гэврийн хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	-	(5,000,000.04)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	286,785,732.00	306,387,732.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(55,222,078.04)	(120,609,216.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,874,135.00	108,747,235.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(31,251,687.18)	(47,199,943.68)
39217	Номын фонд	16,607,809.72	13,283,063.02
39300	Биет бус хөрөнгө	39,425,275.97	38,601,787.88
39301	Программ хангамж	4,084,420.00	4,084,420.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж	(1,745,144.03)	(2,568,632.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,086,000.00	37,086,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	1,488,306,376.74	1,406,646,961.01
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,729,429,185.01	1,757,819,980.39
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	106,797,824.00	43,909,700.00
41300	Өглөг	106,797,824.00	43,909,700.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	50,000.00	-
41311	Цалингийн өглөг	50,000.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	27,446,124.00	-
413203	Түлш халаалтын өглөг	27,446,124.00	-
41360	Бусад өглөг	79,301,700.00	43,909,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	79,301,700.00	43,909,700.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	106,797,824.00	43,909,700.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,622,631,361.01	1,713,910,280.39
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	547,280,406.90	547,280,406.90
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	547,280,406.90	547,280,406.90
51200	Хуримтлагдсан үр дүн	66,133,212.48	157,412,131.86
51210	Өмнөх үеийн үр дүн	(129,849,206.78)	66,133,212.48
51220	Тайлант үеийн үр дүн	195,982,419.26	91,278,919.38

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,009,217,741.63	1,009,217,741.63
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,622,631,361.01	1,713,910,280.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,729,429,185.01	1,757,819,980.39

2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,335,072,500.00	1,539,648,700.00
1310	Улсын төсвөөс	1,152,238,500.00	1,331,460,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,152,238,500.00	1,331,460,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	182,834,000.00	208,188,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	182,834,000.00	208,188,000.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	142,915,147.82	50,884,871.18
1200	Нийтлэг татварын бус орлого	142,915,147.82	50,884,871.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,718,359.00	16,657,142.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	24,718,359.00	16,657,142.80
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	108,395,238.82	28,062,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	9,801,550.00	6,165,728.38
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,477,987,647.82	1,590,533,571.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,275,712,256.35	1,494,944,373.90
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,275,611,020.43	1,493,648,984.49
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	803,103,023.00	949,264,675.00
210101	Үндсэн цалин	479,010,659.00	619,923,212.60
210102	Нэмэгдэл	298,980,186.00	296,758,662.40
210104	Урамшуулал	25,112,178.00	32,582,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,383,309.48	110,840,243.73
210201	Тэтгэврийн даатгал	67,466,960.01	74,998,319.71
210202	Тэтгэмжийн даатгал	7,920,306.71	9,414,053.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,950,359.66	4,667,333.36
210204	Ажилгүйдлийн даатгал	3,862,412.64	4,350,166.44
210205	Эрүүл мэндийн даатгал	15,183,270.46	17,410,370.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,047,074.08	171,607,578.59
210301	Гэрэл, цахилгаан	8,758,504.69	10,340,436.59
210302	Түлш, халаалт	159,290,068.00	159,290,068.00
210303	Цэвэр, бохир ус	1,998,501.39	1,977,074.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,796,750.00	31,882,537.27
210401	Бичиг хэрэг	7,071,715.00	11,943,550.00
210402	Тээвэр, шатахуун	5,573,385.00	6,966,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,067,650.00	9,897,170.00
210408	Бараа материал акталсны зардал	2,084,000.00	3,075,517.27
2105	Норматив зардал	60,714,331.00	80,856,702.00
210502	Хоол, хүнс	60,714,331.00	80,856,702.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,952,206.00	9,436,910.00
210604	Урсгал засвар	13,952,206.00	9,436,910.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,599,530.24	12,319,120.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	842,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,599,530.24	11,476,820.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,014,796.63	127,441,217.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,176,345.00	17,029,680.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	89,838,451.63	110,411,537.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,235.92	1,295,389.41
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	101,235.92	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,235.92	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,295,389.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,295,389.41
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,275,712,256.35	1,494,944,373.90

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	202,275,391.47	95,589,197.28
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	6,292,972.21	4,310,277.90
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,292,972.21	4,310,277.90
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	6,292,972.21	4,310,277.90
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	195,982,419.26	91,278,919.38

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,335,072,500.00	1,539,648,700.00
1310	Улсын төсвөөс	1,152,238,500.00	1,331,460,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,152,238,500.00	1,331,460,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	182,834,000.00	208,188,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	182,834,000.00	208,188,000.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	24,718,359.00	16,657,142.80
1200	Нийтлэг татварын бус орлого	24,718,359.00	16,657,142.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,718,359.00	16,657,142.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	24,718,359.00	16,657,142.80
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,359,790,859.00	1,556,305,842.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,195,818,377.48	1,454,714,610.06
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,169,620,235.56	1,403,057,642.65
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	803,850,110.00	948,559,103.30
210101	Үндсэн цалин	532,408,387.00	619,217,640.90
210102	Нэмэгдэл	245,582,263.00	296,758,662.40
210104	Урамшуулал	25,859,460.00	32,582,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,762,905.24	110,419,132.67
210201	Тэтгэврийн даатгал	67,520,748.13	74,642,859.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,920,306.71	9,397,641.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,950,359.66	4,659,127.07
210204	Ажилгүйдлийн даатгал	3,862,412.64	4,341,959.03
210205	Эрүүл мэндийн даатгал	15,509,078.10	17,377,546.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,047,074.08	199,053,702.59
210301	Гэрэл, цахилгаан	8,881,056.69	10,340,436.59
210302	Түлш, халаалт	159,167,516.00	186,736,192.00
210303	Цэвэр, бохир ус	1,998,501.39	1,977,074.00
2105	Нормативд зардал	32,109,995.00	38,627,076.00
210502	Хоол, хүнс	32,109,995.00	38,627,076.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,952,206.00	8,515,510.00
210604	Урсгал засвар	13,952,206.00	8,515,510.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,599,530.24	14,376,120.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	842,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,599,530.24	13,533,820.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,298,415.00	83,506,998.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,568,915.00	77,354,898.02
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,729,500.00	6,152,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,198,141.92	51,656,967.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,096,906.00	36,968,646.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,096,906.00	36,968,646.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	101,235.92	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,235.92	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	14,688,321.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	14,688,321.41
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	1,195,818,377.48	1,454,714,610.06

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	163,972,481.52	101,591,232.74
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,803,300.00	5,000,400.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	46,803,300.00	5,000,400.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	46,803,300.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,803,300.00	5,000,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	46,803,300.00	5,000,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(46,803,300.00)	(5,000,400.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	117,169,181.52	96,590,832.74
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	62,860,503.95	180,029,685.47
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	180,029,685.47	276,620,518.21

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	(126,849,206.78)	1,429,648,941.75
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,000,000.00)	(3,000,000.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	(129,849,206.78)	1,426,648,941.75
9	Тайлант үеийн үр дүн	-	-	195,982,419.26	195,982,419.26
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	66,133,212.48	1,622,631,361.01
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	66,133,212.48	1,622,631,361.01
19	Тайлант үеийн үр дүн	-	-	91,278,919.38	91,278,919.38
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	157,412,131.86	1,713,910,280.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татаас, санхүүжилтийн орлого	1,633,397,300.00	1,546,305,842.80	87,091,457.20
Улсын төсвөөс	1,355,058,700.00	1,331,460,700.00	23,598,000.00
Урсгал / Урьд оны үлдэгдлээс санхүүжих	59,031,100.00	-	59,031,100.00
Орон нутгийн төсвөөс	208,188,000.00	208,188,000.00	-
Тусламжийн орлого	11,119,500.00	6,657,142.80	4,462,357.20
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,633,397,300.00	1,546,305,842.80	87,091,457.20
Ажиллагчидтай холбогдсон зардал	1,226,522,900.00	1,058,978,235.97	167,544,664.03
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,090,242,700.00	948,559,103.30	141,683,596.70
Цалин	617,399,000.00	619,217,640.90	(1,818,640.90)
Цалингийн тусгай нэмэгдлүүд	472,843,700.00	329,341,462.40	143,502,237.60
Нийгмийн хамгааллын шимтгэл	136,280,200.00	110,419,132.67	25,861,067.33
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	136,280,200.00	110,419,132.67	25,861,067.33

Бараа ,үйлчилгээний урсгал зардал	198,686,400.00	176,261,549.50	23,720,239.91
Тогтмол зардал	208,188,000.00	207,569,212.59	618,787.41
Гэрэл цахилгааны зардал	11,612,900.00	10,340,436.59	1,272,463.41
Түлш, халаалтын зардал	186,141,100.00	186,736,192.00	(595,092.00)
Цэвэр, бохир усны зардал	2,000,000.00	1,977,074.00	22,926.00
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	8,434,000.00	8,515,510.00	(81,510.00)
Хоол	49,784,900.00	38,627,076.00	11,157,824.00
Бусад бараа үйлчилгээний зардал	85,414,400.00	78,842,218.02	6,572,181.98
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	6,152,100.00	6,152,100.00	-
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	16,266,600.00	14,376,120.07	1,890,479.93
Бусад /үдийн цай/	41,068,400.00	36,968,646.00	4,099,754.00
Төвлөрүүлэх	-	1,295,389.41	(1,295,389.41)
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,633,397,300.00	1,442,808,998.06	190,588,301.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	173,123,673.47	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	276,620,518.21	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,161.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,532.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 629.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага тус тус хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Сургуулийн захирлын 2025 оны А/20 дугаар тушаалаар бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-т (*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*) 15.1.3-д (*төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах*) Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т (*Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ*) 4.2.1-д (*зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах*), 6.4-д (*Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:*) 6.4.1-д (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*) Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаалын 2 дугаар хавсралт 3.2. (*Багийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаа нь сургалтын байгууллага, багш эсхүл сургалтын байгууллага хооронд хамтран ажиллах, онол-практикийн хурал, семинар, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, туршлага солилцох уулзалт, мэргэжлийн сэтгүүлд арга туршлагаасаа хэвлүүлэх болон багш солилцооны хөтөлбөрт хамруулах зэрэг хэлбэрээр зохион байгуулагдана*) заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн актыг холбогдох этгээдүүдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоосон

3.2 Албан шаардлага

3.2.1 Сургуулийн хүнсний материалын тайлангаас зарлагын баримт, хоолны ордерыг тулгаж шалгахад хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн, Засгийн газрын тогтоолд зааснаа илүү дүнгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.6 (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*), 20 дугаар зүйлийн 20.2.5 (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), Засгийн газрын 2025 оны 254 дугаар тогтоол 2 (*Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300 (зургаан мянга гурван зуу) төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000 (зургаан мянга) төгрөгөөр тус тус тогтоосугай*) гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний материалын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэх, хоолны зардлыг батлагдсан нормын дагуу тооцож, зарцуулах зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100 хувийг залруулагдаагүй алдаа, зөрчил эзэлж байна. Нийт 2,161.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 2,161.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 12,831.0 мянган төгрөгөөр бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сургуулийн захирлын 2025 оны А/20 дугаар тушаалаар бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.	1	1,532.0	1	1,532.0	-	-	-	-	-	-
Сургуулийн хүнсний материалын тайлангаас зарлагын баримт, хоолны ордерыг тулгаж шалгахад хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн, Засгийн газрын тогтоолд зааснаа илүү дүнгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.	1	629.5	-	-	1	629.5	-	-	-	-
Дүн	2	2,161.5	1	1,532.0	1	629.5	-	-	-	-